

АВТОРИТАР ДЭГЛЭМ**А. ЖАМБАЛ***ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
Эрдэм шинжилгээний ажилтан*

Авторитар дэглэм (Authoritarianism- авторитаризм-латин хэлний “*autoritas*”-бодомж, шийдвэр, засаг гэсэн олон утгатай үгнээс гаралтай, улс төрийн шинжлэх ухаан, социологид засаг гэсэн утгаар ойлгож хэрэглэдэг)- улс төрийн дэглэмийн үндсэн хэлбэрүүдийн нэг (ардчилсан, тоталитар дэглэмийн зэрэгцээ) бөгөөд мөн чанар нь төрийн засаглалын дээд эрх мэдэл, хүч хэрэгсэл нь дарангуйлан захирагч нэг хүн буюу ерөнхийлөгч, эзэн хаан, ерөнхий сайд, төрийн эргэлт хийсэн цэргийн жанжлагч, эсвэл улс төрийн засаглалын нэг байгууллага, аппарат, цөөн тооны хэсэг бүлгийн гарт төвлөрсөн, ардчилал, эрх чөлөө, төлөөллийн байгууллага, иргэний нийгмийн үйл ажиллагаа хязгаарлагдсан, удирдлагад захиран тушаах, албадах арга хэрэгсэл голлож давамгайлсан, улс төр, цэрэг цагдаагийн хүчирхийллийг бэлэн байлгадаг, шаардлагатай бол шууд хэрэглэдэг, бүхэлдээ нийгэм, улс төр, олон нийтийн байгууллага, ашиг сонирхлын бүлгүүдийг дэглэмд бүрэн захирагдахыг шаарддагт оршино. Эл дэглэм дэлхийн янз бүрийн орнуудын улс төрйн түүхэнд эртний боол эзэмшлийн болон дундад зууны феодализмын дарангуй төр, дорно дахин дахь хэрцгий засаг, хэмжээгүй эрхт хаант засаг, шинэ үе ба орчин үеийн цагдаа, цэргийн эрхтний дарангуй дэглэмийн хэлбэрээр, түүхэн тодорхой байдлаар оршоор иржээ. Тухайн оронд тогтсон авторитар дэглэмийн хэр хэмжээ, дарангуй шинж чанар ямар түвшинд байх нь тэр орны нөхцөл байдал, бүрэлдсэн хүчин зүйлсээс шалтгаалдаг, зарим оронд харьцангуй аядуу либерал шинжтэй (тухайлбал 1958-1969 онд Францад тогтсон де Голлийн дэглэм) эсвэл нэн хатуу харгис (Аргентинд тогтсон Пероны дэглэм, Португалд тогтсон Салазарын дэглэм) байдаг, түүгээр нь тус дэглэмийг зүүний аядуу либерал ба барууны чиглэлийн консерватив харгис гэж ялган ангилдаг тал бий. Улс төрийн сэтгэлгээний түүхэнд авторитаризмыг онол, үзэл суртлын үүднээс үндэслэж зөвтгөсөн үзэл санаа, сургаалийг Т. Гоббс, Жозеф дэ Местр, Луи де Бональд, Х. Д.Кортес, Ф.Ю. Шаль, Г. Трейчке, Ш. Моррас нар зохиол бүтээлдээ томьёолон номлож байжээ.

Улс төрийн шинжлэх ухаан авторитар дэглэм эртний үеэс тогтож ирсэн түүхийг анхааран авч үзэж, хамгийн гол нь эл дэглэм орчин үеийн шинж чанар, хэлбэрээр чухамдаа ХХ зуунд Ази, Африк, Европ, Латин Америкийн олон оронд тогтож ноёрхсон жишээ туршлагыг голлон судлаж нэгтгэн дүгнэсний үндсэн дээр авторитар дэглэмийн тухай онолын ерөнхий ойлголт, үзэл баримтлал боловсрон томьёологджээ.

Авторитар дэглэмийн мөн чанар, онцлог шинж нь түүнийг нэг талаас ардчилсан, нөгөөтэйгүүр тотаритар дэглэмтэй харьцуулан авч үзэхэд илүү тодорхой илрэн харагддаг, ер эл дэглэм тэдгээрийн завсрын шинжтэй учир өөрчлөгдөж хувьсахдаа харьцангуй аядуу, эсвэл дарангуй чанарын аль нь голлож давамгайлсан байдлаас шалтгаалж нэг бол ардчилсан, эсвэл тоталитар дэглэмд шилжиж хувирдаг. Авторитар ба тоталитар дэглэмийн аль аль нь ардчиллын эсрэг дарангуй дэглэм бөгөөд тэдгээрийн ижил төстэй шинж илрэлүүдийг илүү анхаарч товойлгох, харин мөн чанарлаг, зарчмын ялгааг дутуу судлах явдал тэдгээрийг хооронд нь адилтгаж нэг л дарангуй дэглэмийн хоёр янзын илрэх хэлбэр гэж үзэхэд хүргэнэ. Тоталитар дэглэм улс төрийн ямар нэг намд тулгуурлаж, тодорхой нэг үзэл суртлыг хатуу баримталж, нийгмийн бүхий л амьдралыг түүнд хүчээр нийцүүлж өөрчлөн байгуулахыг зорилго болгодог, үүний тулд нийгмийн амьдралын бүх хүрээ, салбарыг нам, төрийн байгууллага, ялангуяа тусгай албадын хатуу хяналтанд байлгадаг, хүчирхийлэл, албадлага, залхаан цээрлүүлэлтийг гол хэрэгсэл болгодог бол авторитар дэглэм нь улс төрийн нам, үзэл сурталд биш харин цэрэг арми, шашин, үндэсний уламжлалд тулгуурладаг, хамгийн гол нь улс төрийн засаглалын монополь эрх, халаа сэлгээгүй байдлыг хадгалах, иргэний нийгэм, улс төрийн хүчнүүдийн зүгээс засгийн эрх мэдлийн төлөө үүсэж болох тэмцэл, аливаа оролдлого, санаархал халдлагаас болгоомжлон сэрэмжлэхэд илүү их анхаардаг онцлогтой. Авторитар дэглэм үүний дагуу улс төрийн сөрөг хүч, нам, эвсэл холбоо, хөдөлгөөнийг цагдаж хориглодог, хэрэв тэдгээрийн оршин тогтнол, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрвөл тухайн дэглэмийн хүрээнд, түүний хатуу хараа хяналтын доор зөвшөөрч хязгаарлан барина. Ийм нөхцөлд авторитар дэглэмтэй жинхэнэ ёсоор сөргөлдөх, өрсөлдөж тэмцэх улс төрийн бодит тодорхой хүч оршин байх аргагүй болно. Төрийн дээд эрх мэдлийг халаа солиогүй дангаар эзэмшиж ноёрхсон улс төрийн дарангуй элит бүрэлдэж

бий болно, тэр нь хаалттай, явцуу хүрээтэй байх ба эгнээ бүрэлдэхүүнээ дотроосоо сэлбэнэ. Үүнтэй уялдаж авторитар дэглэмийн үед тухайн улс орны дотоод гадаад бодлого, нийгмийн амьдралын амин чухал асуудал, зорилтуудыг улс төрийн янз бүрийн хүч, олон түмний оролцоотойгоор, ардчиллын зарчмаар шийдвэрлэх бололцоо, арга зам хэрэг дээрээ байдаггүй.

Авторитар дэглэмийн эрх баригчдын дээд эрх мэдэл хууль ёс, эрх зүйгээр хатуу зохицуулагддаггүй, иргэний нийгэм, олон түмний хяналтаас гарсан байдаг, зарим тохиолдолд дарангуйлагч этгээд тус дэглэмийг хууль ёс, эрх зүйн дагуу тогтоож хэрэгжүүлдэг үндсэн хуультай байх туршлага байдаг боловч тэр нь ард олны эрх ашиг, хүсэл зоригийн дагуу, тэдний оролцоотойгоор биш, харин эрх баригчдаас нийгэмд хүчээр тулгаж хүлээлгэсэн хэрэг байдаг. Авторитар төр нь үүгээрээ жинхэнэ эрх зүйт төр биш, дэглэмээс тогтоож тунхагласан үндсэн хууль, эрх зүйн бусад тогтоомж нь хэлбэр төдий, дэглэмийн ноёрхол, дарангуйллыг халхлан далдалсан зүйл байдаг. Авторитар дэглэм тоталитаризмаас ялгаатай нь нийгмийн амьдралын социаль хүрээ буюу хүмүүсийн гэр бүл, хувийн амьдрал, аж төрөх байдал, хэрэглээ, хувийн өмч, эдийн засаг, шашин шүтлэг, соёл, урлагийг тус дэглэмийн хяналт зохицуулалтын хүрээнд харьцангуйгаар чөлөөтэй байлгадаг, ямар нэг үзэл суртал, нийгмийн байгууллын аль нэг хийсвэр загвар, хөгжлийн замыг дангаар нь сонгож баримталдаггүй, нийгэм соёлын цоо шинэ үнэт зүйлсийг бий болгож нийгэмд тулган хүлээлгэдэггүй, энэ нь авторитар дэглэмийн нөхцөлд иргэний нийгэм хүч сул ч гэсэн тодорхой хэмжээнд бие дааж оршин тогтнох нөхцөл боллцоог бий болгодог, тэр нь эргэж тус дэглэм тухайн улс оронд нийгэм, ард олны зүгээс ноцтой ширүүн эсэргүүцэл тэмцэлтэй тулгарахгүйгээр харьцангуй удаан, тогтвортой оршин тогтоход нөлөөлдөг.

Авторитар дэглэм голцуу аль нэг улс орон нийгмийн нэг байгууллаас өөр байгуулалд шилжих үед, эдийн засаг, нийгэм нь буурай дорой, улс төр тогтворгүй нөхцөлд тэдгээр бэрхшээл, хурц асуудлыг даван туулж шийдвэрлэхэд үүсэж бүрэлдсэн ээдрээ зөрчилтэй нөхцөл байдал, сөрөг хүчин зүйлсийн нөлөө шаардлагаар төрийн засаглалыг чангалж, удирдлагыг төвлөрүүлэн иргэд, нийгэм, улс төрийн субъектуудын эрх чөлөө, ардчиллыг хязгаарлах явцад тогтож ноёрхсон жишээ туршлага нийтлэг байна. Зарим оронд эдгээр бэрхшээл, асуудал хурцдан гүнзгийрч улмаар иргэний болон угсаатан хоорондын дайн гарах, улс орны тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал алдагдахад хүрч түүнийг дотооддоо хатуу дэглэм тогтоож шийдвэрлэхээс аргагүй болсны үр дагавараар хүчтэй авторитар дэглэм тогтсон жишээ туршлага ч бий. Өөрөөр хэлбэл авторитар дэглэм аль нэг оронд түүхэн тодорхой нөхцөл, хүчин зүйлсийн нөлөө, учир шалтгаанаар тогтдог бөгөөд тиймээс түүнийг хэн нэг дарангуй бие хүн, хэсэг бүлэг этгээдийн субъектив хүсэл зоригоор тогтдог мэтээр хялбарчилж, гуйвуулан ойлгож болохгүй, тэгэхдээ тийм субъектив хүчин зүйлийг анхаарч тооцох хэрэгтэй.

Авторитар дэглэмийг практикийн хувьд эсэргүүцэн тэмцдэг улс төрийн сөрөг хүч, мөн онол, үзэл суртлын үүднээс шүүмжлэн няцаадаг улс төр судлагч, нийгмийн ухааны эрдэмтэд нийгмийн шилжилт, шинэчлэл хийх, эдийн засаг, нийгэм, улс төр, соёлын хоцрогдол, бусад хурц бэрхшээл, асуудлыг ардчилал, эрх, эрх чөлөөг хязгаарлан хумихгүйгээр, нэг үгээр хэлбэл авторитар дэглэмгүйгээр ардчилсан, аядуу арга замаар шийдвэрлэж болно гэж үздэг. Үүнийг бүхэлд нь мөн түүхэн тодорхой тохиолдолд үгүйсгэн няцааж болохгүй. Ардчилал, ардчилсан дэглэм нь хүмүүсийн эрх, эрх чөлөөг хангаж, тэдний идэвхтэй, бүтээлч үйл ажиллагааг өрнүүлдэг нь нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын хоцрогдол, бэрхшээл, тулгамдсан асуудал, зорилтыг шийдвэрлэхэд ихээхэн ач холбогдолтой. Гэхдээ ардчилал, эрх чөлөө нь хэдийгээр нэн чухал түгээмэл үнэт зүйл, эрхэмлэл мөнболовч тэдгээр нь бодит амьдрал дээр уг ёсоороо, зүй зохистой хэрэгжин биелэх, үр дүнтэй байх эсэх нь тухайн орны түүхэн тодорхой нөхцөл байдал, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн түвшин, улс төрийн уламжлал, хүн ардын аж төрөх ёс, ухамсар, сэтгэл зүйн шинж чанар, онцлогоос шалтгаалж ямагт түүхэн тодорхой байдалтай, улс орон бүрт харилцан ялгаатай, эерэг, сөрөг үр дүнтэй байдаг. Ардчилал, ардчилсан дэглэм бол нийгэм, эдийн засаг, улс төр, соёлын бүх асуудал, бэрхшээл, зорилтыг амжилттай шийдвэрлэх бэлэн зэлэн түгээмэл хэрэгсэл хараахан биш. Нийгэм, эдийн засаг, соёлын буурай доогуур түвшин, хямрал улс төрийн сөргөлдөөн, тэмцэл, тэдгээрийг дагалдсан нийгмийн тогтвортой байдал нь ардчилал, хүний эрх, эрх чөлөөний үндэс суурь болдоггүй, харин ч эсрэгээр улс төрийн хатуу дэглэм тогтох үндэс шалтгаан болдог явдал түүхэнд зонхилж иржээ. Авторитар дэглэм ХХ зуунд чухамдаа Европын хөгжил дэвшилтэй, дундад зуун, шинэ ба нэн шинэ үед учирсан бэрхшээл, хурц асуудал, зорилтуудыг даван туулж чадсан, тэр явцад ардчиллын уламжлалтай болсон орнуудад биш, харин Ази, Африк, Америкийн буурай, ардчилсан уламжлал сул, хүн амын ихэнх хэсэг нь тариачид, нийгмийн бусад жижиг давхраанаас бүрэлдсэн, улс төрийн ухамсар, соёл дутмаг, эдгээрийг даван туулж нийгмийн модернизаци хийх зорилттой тулгарсан, шилжилтийн үеийн орнуудад ихэвчлэн тогтсон байна.

Авторитар дэглэм тогтож байсан орнуудын туршлагаас үзэхэд эл дэглэм тухайн оронд удаан хугацаагаар, хахир хатуу нэг хэвээр хадгалагддаггүй, харин ч өөрийн дотоод сурвалж хүч, нийгмийн хөгжил дэвшил, олон улсын амьдрал, гадаад харилцааны өөрчлөлт, дэвшлийн нөлөөгөөр эерэг чиглэл хандлагаар хувьсан өөрчлөгдөж шилжилтийн шинж чанартай болсон нь дэлхийн II дайны дараах үед тодорхой харагдах болжээ. Энэ нь авторитар дэглэмийн өөрийн нь хүрээнд дотор явагдах эдийн засаг, нийгэм, соёлын өөрчлөлттэй

холбоотой. Эл дэглэмийн нөхцөлднийгмийн социаль хүрээ, эдийн засаг, хувийн өмч, соёл, боловсрол харьцангуй чөлөөтэй байдаг нь тэдгээрийн бие даасан байдал, өөрчлөлт хөгжилд чухлаар нөлөөлдөг бөгөөд түүнийг дагаж хүн амын амьдралын түвшин аажим дээшлэн нийгмийн бүтэц өөрчлөгдөж хувийн өмчтэй, жижиг дунд үйлдвэрлэл, сайжирсан газар тариалан, хөдөө аж ахуй эрхэлсэн, түүгээрээ эдийн засгийн талаар авторитар төрөөс хараат бус дунд анги, давхраа бүрэлдэн бий болж нийгэмд зонхилох байр суурь эзэлдэг байна. Энэ нь нийгэм, улс төрийн амьдрал аажим ардчилагдах, иргэд эрх, эрх чөлөөтэй болох, бүхэлдээ авторитар дэглэм сулран аядуу болж ардчилалд шилжих үйл явцыг нөхцөлдүүлдэг ажээ. Зүүн өмнөд Ази, Латин Америкийн хэд хэдэн оронд тогтож байсан авторитар дэглэм ийм байдлаар хувьсан өөрчлөгдөж ардчилалд шилжжээ. Гэвч авторитар дэглэм орчин үед Ази, Африк, Латин Америкийн нэлээд оронд өөр өөрийн онцлогтой тодорхой хэлбэрээр, мөн нийтлэг шинж байдлаар оршиж байна.

НОМ ЗҮЙ:

1. IPSA Encyclopedia, Kurian (eds) Encyclopedia (2010)
2. Linz J.J Totalitarian and Authoritarian Regimes. Handbook of Political Science b.3. Macropolitical Theory. Massachusettts, 1975
3. Политология: Энциклопедический словарь. М., 1993
4. Социологическая энциклопедия. В двух томах. Том 1. А-М. М., 2003
5. Философский энциклопедический словарь. 2-е издание. М., 1989
6. Улс төрийн шинжлэх ухаан. Нэмж засварласан хоёр дахь хэвлэл. УБ., 2010
7. Ё. Довчин. Харьцуулсан улс төр. УБ., 2006